



ДУНДГОВЬ АЙМАГ
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Додо оны 11 сарын 11 ёдөр

Дугаар 114

Хараат

Г Коронавируст (Ковид-19) цар тахлаас
урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /б/, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 62, 64 дүгээр тогтоол, Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 159 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 15 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны А/331 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

2. Иргэдийг коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийг хамарсан соёл урлаг, спортын арга хэмжээ, сургалт, цуглааны үйл ажиллагааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

3. Сумын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

4. Сумаас орох, гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдрийг дуустал хугацаанд түр зогсоосугай.

5. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлж ариутгал, халдварт хамгааллын дэглэмийг сайтар сахихыг нийт ард иргэд болон төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.

6. Тусгаарлах байрнуудын бэлэн байдлыг хангах.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлага, мэдээллээр хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын нийт бүрэлдэхүүн, шуурхай штаб (З.Солонго), цагдаагийн хэсэг (Б.Азжаргал), эрүүл мэндийн төв (О.Энхмаа), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Д.БУДЖАВ

